



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/18

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Галшар сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Баян-Овоо сумын сургуулийн барилгын их засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Б.Цэрэнчимэд	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010122